

ГХБХБГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2024.07.25

Сайнцагаан сум

Тус байгууллагын даргын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ёс зүйн дэд хороо тайлант хугацаанд 1 удаа хуралдсан ба хуралдаанаар 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, 5 арга хэмжээг төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, тус байгууллагын даргаар 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр батлуулсан.

Сургалт, сурталчилгаа

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.4 дэх заалт “хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах”-ын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг байгууллагын “Мэдээллийн самбар” болон www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудасны “Үйл ажиллагааны ил тод байдал” хэсэгт байршуулж, олон нийтэд ил тод мэдээллэж, сурталчилж байна.

- 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссаны дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр тус байгууллагын нийт албан хаагчдад Газрын даамлуудыг чадахижуулах сургалтын үеэр дотоод сургалт зохион байгуулж, Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулинд төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмын талаар өөр хоорондоо ижил төстэй ойлголт болон ялгаатай байдлыг харилцан ярилцсан. Сургалтад нийт 16 албан хаагч хамрагдсан.



- Ёс зүйн дэд зөвлөлөөс байгууллагын соёлыг нэмэгдүүлэх, хувь хүний ёс зүйг төлөвшүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах, хамт олны дунд найрсаг халуун дулаан харилцаа бий болгох зорилгоор 2024 оны сургалтын төлөвлөгөөнд хувь

хүний сургалтыг зохион байгуулах санал гаргаж тусгагдсны дагуу “Байгууллагын соёл, ёс зүй, хандлага” сэдэвт сургалтыг Дундговь аймаг дахь Эмэгтэйчүүдийн салбар зөвлөлөөс, “Гэр бүлийн харилцаа” сэдэвт сургалтыг Гэр бүл, хүүхэд хөгжлийн газраас авч 28 албан хаагч бүрэн хамрагдсан. Сургалтын дараа асуулт хариултын цагаар албан хаагчдаас сэтгэл ханамжтай байгаа талаар талархал, сэтгэгдэл сонссон.



Тайлан, мэдээ, судлагаа

Эхний хагас жилийн байдлаар дараах мэдээлэл, судалгааг Дундговь аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хугацаанд нь хүргүүлсэн байна. Үүнд:

- “Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны мэдээлэл”
- Албан хаагчийн ёс зүйтэй холбоотой ирсэн гомдол, түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл
- ЗДҮАХ-ийн 4.2-т тусгагдсан “Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил 2020 онд 10 хувьтай байсныг 2024 онд 4 хувиар бууруулна” зорилтын хэрэгжилт
- Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх тайлан
- Ёс зүйн дэд хорооны мэдээлэл

2020 оноос хойш тус байгууллагын албан хаагчид ёс зүйн зөрчил гаргаагүй, ёс зүйн хариуцлага хүлээсэн албан хаагч байхгүй, иргэдээс албан хаагчтай холбоотой гомдол мэдээлэл ирүүлээгүй нь Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа тогтмолжсны үр дүн юм.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.БОЛОРЧИМЭГ